

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Банзрагч	Дугаар	L233
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Тэшиг сумын 2-р баг
Төрсөн газар	Тэшиг	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шээжингийн хурал	Сүм хийдийн дугаар	БУТШ 011
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат

Булган аймгийн Тэшиг сумын Шээжингийн хурал

Д.Мөнхбат: За өнөөдөр 2007 оны 7-р сарын 30-ны өдөр . Манай судалгааны баг Булган аймгийн Тэшиг сумын 2-р багийн нутаг тус сумын уугуул өндөр настан Банзрагч гуайгаас дараах ярилцлагыг авсан юмаа.Хуучнаар Түшээт хан аймгийн Дайчин Вангийн хошуу буюу одоогийн Булган аймгийн Тэшиг сумын нутагт байгаа 1937-1938 оноос өмнө үйл ажиллагаагаа явуулж байсан эдүгээ академич Ренчин гуайн жагсаалтад бүртгэгдсэн энэ сумын нутаг дахь 11 Буддын шашны сүм хийдийн нэг болох Эгийн голын ард байдаг энэ 2-р багийн нутаг дахь Хөндийн амны адаг гэдэг газар байрладаг Шээжингийн хурлын дуганы талаар дараах ярилцлагыг өрнүүлсэн юмаа. За танаас би тэгэхээр Шээжингийн хурлын тухай товчхон хэдэн асуулт лавлая. Тэгэхээр энэ дуган бол нэг дуган байсан уу, хоёр дуган байсан уу, гурван дуган байсан уу. Энэ талаар та бас нүдээр үзэж байсан хүний хувьд яг хэдэн дуган байсан юм бол оо?

Банзрагч: Ганц л дуган байсан юмаа.

Д.Мөнхбат: Ер нь хэдэн лам нар хурдаг байсан юм бэ?

Банзрагч: Тэрийг ч мэдэхгүй нэг 10-аад лам байсан юм даг. Би чинь цай ундыг нь тагштай нь зөөж өгч байсан юм.....манзыг нь хийж байсан юм

Д.Мөнхбат: Манз гэдэг чинь одоо хоол цайг нь л зөөж явсан?

Банзрагч:Аа тийм хоол ундыг нь цав,....цайг нь манз л гэдэг юм

Д.Мөнхбат:Тэгэхээр энэ нэг дугантай 10-аад ламтай байсан гэхээр цагийн хурал байсан юм болов уу?

Банзрагч:Аа мэдэхгүй намайг одоо өвөл зун ирэхэд амьтан хүн цуглачихсан ном хураад л сүйд болдог байсан юм даг

Д. Мөнхбат: Хавартаа бас хурах уу ,цагаан сарын дараа?

Банзрагч: Өө мэдэхгүй зун л хурж байсан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Д.Мөнхбат: Өвөл яахав?

Банзрагч: Өвөл ч одоо нэлээн хаагдана. Тэгээд нэлээн шажин цэгцэрсэн нэлээн айхтар хатуу үе шинэ цаг эхэлсэн.

Д. Мөнхбат: Тэгэхээр энэ одоо цагийн хурлын тэр 10-аад лам дотор ловон лам гэдэг юмуу, тэргүүн лам нь ямар хүн байсан юм бол ,энэ талаар таньд одоо хөгшчүүлийн ярьж байсан нь санагдаж байгаа юм байна үү?

Банзрагч: Аа баригдаад явчихсан юм. Данзан гэлэн гэж байсан юм, Жанцан гэлэн гэж байсан юм , Гэндэн гэлэн гэж байсан юм хэдэн улсууд байдаг байсан юм

Д.Мөнхбат: Тэр намрын цагт өдөржин хурчихаад тэр олон гэлэнгүүд ойролцоох сүм хийд рүүгээ буцдаг байсан юм болов үү? Эсвэл гэр орон нь хөдөөлчихдөг байсан юм боловүү?

Банзрагч: Хөдөөлчихдөг юм.

Д.Мөнхбат: Ер нь энэ бүс нутагт байгаа Буддын шашны томоохон хийд болох Даян дээрхийн хийд ч гэдэг юм уу, одоо эсвэл энэ Тэшиг сумын нутагт байсан Эрингийн хурал болох хурал тэдгээртэй ер нь ямар холбоотой байсан юм бол, одоо энд тэндхийн хүрээнээс ч юмуу лам нар ирж байсан юм боловүү?

Банзрагч: Үгүй одоо энэ чинь... би Даян Дээрхд нэг мөргөсөн л юм.Бадарч мадарч гээд л Даян Дээрхийн хүрээнд байдаг байсан юм

Д.Мөнхбат: Ер нь энэ Эрингийн хурал бас цагийн хурал байсан юм болов үү, ганц дугантай, тэгсэн мөртлөө бас нэлээн хэдэн ламтай байсан юм байна лээ, Тэгэхээр Эрингийн хурлын нэг онцлог бол цам гарч майдар эргэдэг байсан юм байна. Тэгэхээр энийг бол Даян Дээрхийн хүрээнээс лам нар ирж хийдэг байж.Энд тийм зан үйлийн зүйл явдаг байсан юм болов үү?

Банзрагч: Энэ лам нар Эрин дээр нэг тэгж юу яахыг нь үзсэн юм байна.Шээжингийн хурал дээр бол байгаагүй. Үгүй Шээжингийн хурал чинь өндөр дээд сахиус яагаад яагаад ч гэлээ гэмтсэн тийм учраас тэгж ингэж гээд энэ Шээжингийн хурлыг хуралдуулсан юм гэнэ лээ

Д.Мөнхбат: Хурал, жас сангийн хувьд энэ дуган ямархуу байсан юм бол доо, одоо өөрийн мэдлийн сүсэгтэн олны хандив өргөлөөр ирсэн мал ямархуу юм байсан юм бол?

Банзрагч: Аа тэр чинь тийм мал бол тусдаа байсан байх

Д.Мөнхбат: Энэ одоо сүм дуган хурлууд том жижиг гэлтгүй өөрийн шүтээн сахиустай байдаг тиймээ.Шээжингийн хурлын гол шүтээн сахиус нь ямар бурхан байсан юм бол оо?

Банзрагч: Аа ёстой мэдэхгүй юм даа

Д. Мөнхбат: Ер нь энэ хавийн сүсэгтэн олон одоо ард түмэн гэдэг юмуу голдуу ямар бурхан тахидаг байсан юм бэ?Тэр л бурхан байсан байх даа тиймээ, тэр хурлын.

Банзрагч: Тийм л байх даа , одоо мэдэхгүй юмаа

Д.Мөнхбат: Одоо зарим нутагт Говийн Лха гэдэг ч юмуу, зарим аймагт Лхам бурхан гэдэг ч юмуу Буддын шашны бурхнаас чинь нэг нэг бурхныг одоо тэр хошуу нутгаараа тахидаг байж дээ. Энэ хавьд одоо ямар бурхан тахидаг байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Банзрагч: Аа мэдэхгүй энэ хавьд чинь одоо хувилгаан гэж нэг юмыг л шүтдэг, тэгээд хаварт өнөөх идээ будаагаа тавьдаг...Банзрагч ,Сүндүй, Алтангэрэл гээд л ном уншуулдаг юм

Д.Мөнхбат:Тэгэхээр та түрүүн бас товч ярьж байсан 44 онд цэрэгт яваад 4 жил алба хаачихаад буцаад ирэхэд бол уг нь байж байсан гэж байгаа тиймээ? Одоо үлдэгдэл нь?

Банзрагч: Тэгээд ирээл байхгүй болчихсон байсан

Д.Мөнхбат: Тэгвэл таныг цэрэгт явахаас өмнө нураасан гэсэн үү, Яг одоо нураагаад хааш нь шилжүүлээд ямар зорилгоор нураасан гэсэн мэдээ байна уу?

Банзрагч: Аа тэр цэргийн тэр хэдэн залуус л байсан юм шиг байгаа юм , тэр нураасан хүмүүс нь.Гэхдээ сумын дарга нарын даалгавраар. Би бас дотор нь л явлаа./инээв/

Д.Мөнхбат: Бас нураахад хувь нэмрээ оруулж л явлаа гэж үү, тэгээд сургууль барьсан уу үгүй юу, энэ лам нарыг бариад явсны дараа бага сургууль хичээллүүлсэн үү үгүй юу?

Банзрагч: Сургууь ч одоо...намайг нэг 14 тэй байхад...би 14-тэй л байсан юм, шинэ үсэг зааж байна гээд л хэсгийн төвд майхантай сууж байсан юм даа ...хөөрхий

Д.Мөнхбат: За танд их баярлалаа. Таны өгсөн энэ мэдээлэл манай судалгааны ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.